

**БАРГИЛТЫН ИЛ УУРХАЙН ТЭСЭЛГЭЭНИЙ АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ
ТЕХНИКИЙН ДААЛГАВАР**

№	Ажлын нэр төрөл	Тавигдах шаардлага
1	Ажил гүйцэтгэх үндэслэл	“МОНГОЛПРОСВЕТМЕТ” ТӨҮГ-ын Бор-Өндөр уулын баяжуулах үйлдвэрийн уулын цехийн баргилтын ил уурхайд батлагдсан зураг төсөл (ТЭЗҮ), батлагдсан уулын ажлын төлөвлөгөө, захиалагч талаас өгсөн чиглэл, зааварчилга болон ХАБЭА-н дүрэм, журам, бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд уурхайн уулын цулыг сийрэнжүүлэх тэсэлгээний ажлыг хийж гүйцэтгэнэ.
2	Захиалагч байгууллага	“МОНГОЛПРОСВЕТМЕТ” ТӨҮГ
3	Төслийн байршил	“МОНГОЛПРОСВЕТМЕТ” ТӨҮГ-ын Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт орших “Баргилт”-ын төмрийн хүдрийн ил уурхай дээр
	Гэрээт ажлын зорилго	Зорилго: “Бор-Өндөр”УБҮ-н Баргилтын ил уурхай дээр “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай” хууль, “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”, “Ил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”, “Бор-Өндөр” УБҮ-н ил уурхайн аюулгүй ажиллагааны зааварчилга, “Тэсэлгээний ажил гүйцэтгэх журам”, “Тэсэлгээний ажлын горимууд”, бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт орших Баргилтын төмрийн ордын ил уурхайн хөрсний чулуулаг болон хүдрийн тэсэлгээний ажлаар стандартын шаардлагад нийцсэн чанартай бүтээгдэхүүн, дэвшилтэд технологиор тэсэлгээний ажлыг мэргэжлийн өндөр түвшинд аюул осолгүй хийж гүйцэтгэхэд энэхүү ажлын зорилго юм.
4	Гүйцэтгэх ажил	<p>1. Талбайн хамрах хүрээ: Бор-Өндөр уулын баяжуулах үйлдвэрийн уулын цехийн Баргилт хэсэг</p> <p>1.1. Ордын уул геологийн нөхцөл, чулуулгийн тогтоц, шинж чанараас шалтгаалан гэрээний хүчинтэй хугацаанд ил уурхайн уулын цулыг тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлээр бүрэн хангаж, иж бүрэн тэсэлгээний ажлыг хийж гүйцэтгэх.</p> <p>1.2. Гүйцэтгэгч нь тэсэлгээний ажлын үр дүнд хүдрийн бутлагдлын хэмжээг 300 мм, хоосон чулууллагт 500 мм-ээс ихгүй болгож бутлан сийрэгжүүлэх үүргийг хүлээнэ.</p> <p>1.3. Тэсэлгээнээс үүссэн овор хэтэрсэн чулууллагт гүйцэтгэгч тал өөрийн зардлаар шаардлагатай тоо хэмжээнд хүргэж бутлалт хийнэ.</p> <p>1.4. Уурхайн хажуу, доголын налуууг тооцож, ӨТА-н паспортыг зохиох бөгөөд тус паспортын дагуу тэсэлгээний ажил гүйцэтгэнэ.</p> <p>1.5. Талууд тэслэхэд бэлэн блок, тэсэлсэн блокуудыг цаг тухай бүр акт үйлдэж 2 талаас хүлээлцэнэ.</p> <p>1.6. Тухайн жилийн тэслэгдэх уулын цулын төлөвлөгөөнд тулгуурлан тэсрэх материал, тэсрэх бодис татан авах, нөөцлөх календарчилсан төлөвлөгөө боловсруулж баталсан байх ба захиалагч талд танилцуулж ажиллана.</p>

- 1.7. Уурхайн мөргөцгийн улыг төлөвлөсөн өндөршилт түвшингийн зөрүү ± 20 см-н хэлбэлзлийг зөвшөөрөх ба хэтрүүлсэн тохиолдолд гүйцэтгэгч өөрийн зардлаар засварлана. Мөргөцгийн улыг маркшейдер багаж ашиглан хяналт тавина.
- 1.8. Тэсэлгээний ажлаас шалтгаалан хүдрийг бохирдуулсан тохиолдолд захиалагч болон гүйцэтгэгч талаас хамтарсан акт үйлдэж, тухайн хүдрийг нээхэд хуулсан хөрсний өртөг, бохирдсон хүдрийн үнээр тооцон тэсэлгээний ажлын гүйцэтгэлээс хасаж тооцно. (Уурхайн ашиглалтын геологи хүдрийн биетийн хүрээ тавьж акт үйлдэнэ).
- 1.9. Тэсэлгээний ажлын тэсрэх бодис болон тэсрэх хэрэгсэлийн хувийн зарцуулалтын нормыг оновчтой тогтоож, мөрдөж ажиллана. (тэсрэх бодисын хувийн зарцуулалтын норм нь УБҮ-н одоо мөрдөж буй нормоос ихгүй байна).
- 1.10. Хөрсний чулуулгийн бутлагдлын чанарыг сайжруулах, чулуулгийн шилжилт, хөрсний тархалтыг багасгах, тэсэлгээний улмаас гарах аюул, ослыг багасгахын тулд тэсэлгээний хэрэгслийг хором удаашруулсан үйлчилгээтэй чанар сайтай тэсрэх бодис үйлдвэрийн алдаа багатай тэслэх хэрэгслийг сонгон ажиллах.
- 1.11. Захиалагч талаас уулын ажлын өрөмдлөгийн ажилд доголдол гарсан тохиолдолд гүйцэтгэгч тал өөрийн нөөц бололцоонд тулгуурлан өрөмдлөгийн ажлыг хийж гүйцэтгэж болно. (Өрөмдлөгийн ажлын хэмжээг 2 тал харилцан тохиролцоно).
- 1.12. Уулын ажлуудыг гүйцэтгэхдээ Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг чанд баримтлан ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдал, эрүүл ахуйг бүрэн хариуцаж ажиллах бөгөөд холбогдох менежментийн системийг боловсруулан, захиалагчаар батлуулж, гэрээт хугацаанд үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллана.
- 1.13. Уурхайн технологийн ажлуудад зориулан аюулгүй ажиллагааны журам боловсруулан Захиалагч талаар батлуулан үйл ажиллагаандаа мөрдүүлж ажиллах бөгөөд шаардлагатай эрсдэлийн үнэлгээг хийсэн байна.
- 1.14. Захиалагч талын инженер техникийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны ажилтнуудыг ажлын талбайд зохих журмын дагуу саадгүй нэвтрүүлэх бөгөөд тэдгээр ажилтны холбогдох дүрэм журамд нийцүүлэн тавьсан шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.
- 1.15. Гүйцэтгэгч талын инженерүүд төлөвлөсөн блокын хүрээнд тэсэлгээний ажил хийгдэх цооног төлөвлөлтийг зориулалтын программ хангамжийн тусламжтайгаар хийж гүйцэтгэнэ.
- 1.16. Цооногийн түгжээсийг зориулатын шаардлага хангасан материалаар хийнэ.

5	Ажиллах хүч	<p>2.1. Гүйцэтгэгч нь өрөмдлөг тэсэлгээний ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай ажлын баг, ажиллах боловсон хүчээр бүрэн хангагдсан байна.</p> <p>2.2. Гүйцэтгэгч нь уул уурхайн болон өрөмдлөг, тэсэлгээний чиглэлийн мэргэжлийн сургалтад бүрэн хамрагдсан хүчин төгөлдөр тэсэлгээчний нэгдсэн үнэмлэхтэй, тэсрэх материалтай харилцах эрхтэй инженер техникийн ажилчдын баг бүрэлдэхүүнтэй байна.</p> <p>2.3. Гүйцэтгэгч нь байнга байх дараах голлох боловсон хүчинтэй байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Тэсэлгээний ажлын удирдагч (4 –өөс доошгүй жилийн туршлагатай) • Тэсэлгээчин буюу тэсэлгээний ажилтай харьцах эрхтэй туслах ажилтан (2–оос доошгүй жилийн туршлагатай) • Нярав
6	Техникийн шаардлага	<p>3.1. Гүйцэтгэгч нь 3-аас доошгүй жилийн ажлын дадлага, туршлагатай, өмнө нь ижил төрлийн уурхайн өрөмдлөг тэсэлгээний ажил, үйлчилгээ гүйцэтгэж байсан туршлагатай байх.</p> <p>3.2. Гүйцэтгэгчийн баг бүрэлдэхүүн нь (Уурхайн тэсэлгээний ажил гүйцэтгэх ажилтнууд нь) ажил үүргээ аюул, осолгүй, технологийн горимын дагуу хэвийн явуулах тоног төхөөрөмж, ажлын багаж, төхөөрөмж хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслээр бүрэн хангагдсан байна.</p> <p>3.3. Цаг ашиглалт болон техникийн бэлэн байдлыг 90-аас доошгүй хувьтай байлгана.</p> <p>3.4. Гэрээний хугацаанд ХАБЭА, БО-ны холбогдолтой хууль, дүрэм, журам зөрчигдсөнөөс үүдэлтэй бүтээлийн алдагдал, цаг хугацаа, үйл ажиллагаатай холбоотой шууд, шууд бус хохирлыг Гүйцэтгэгч тал бүрэн хариуцана.</p> <p>3.5. Үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, үйлдвэрлэх, тэсэлгээний ажил явуулах тусгай зөвшөөрөлтэй байх.</p> <p>3.6. Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн дагуу боловсруулсан дүрэм журмуудтай байх.</p> <p>3.7. ХАБЭА, БО тухай хуулийн дагуу Гүйцэтгэгчийн бүх ажилтан ажиллагсад өөрийн компанийн аюулгүй ажиллагааны сургалт, зааварчилгаанд бүрэн хамрагдсан, уурхайн талбайд аюулгүй ажиллах ойлголт мэдлэгтэй, түүнийг нотолсон сургалтад хамрагдсан бүртгэлийн хуудастай байна.</p> <p>3.8. Гүйцэтгэгч нь ЭНТБ болон эмульсийн тэсрэх бодисоор цооног цэнэглэгч тусгай зориулалтын машин техниктэй байна.</p> <p>3.9. Гүйцэтгэгчийн бүх тээврийн хэрэгслүүд болон түүнийг ажиллуулах операторууд тээврийн хэрэгслийн болон жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдсан байна.</p>

		<p>3.10. Тэсэлгээний ажлыг гүйцэтгэх шаардлагатай техник хэрэгсэл, машин механизмаар бүрэн хангагдсан байна. Уулын ажлын төлөвлөгөө, зураг төсөл, Уурхайн уулын ажлын горим, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн уулын ажил хийх хангалттай хүчин чадалтай, иж бүрэн үндсэн тоног төхөөрөмжүүдтэй байна.</p>																																
7	Төлбөр тооцоо	<p>4.1. Тэсэлгээний ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай машин техник, тоног төхөөрөмжийг засварлах засварын мэргэжлийн баг бүрэлдэхүүнтэй, ажлын байр, ахуй хангамжтай холбоотой асуудлыг стандартын дагуу, бүрэн шийдвэрлэнэ.</p> <p>4.2. Гэрээний дагуу тэсэлгээний ажил 2024 онд нэг м3 нь 2850 төгрөг байх ба нийт тэсэлгээ хийх уулын цул 4,811,935 м3 байна. Энэ дүн нь НӨАТ багтсан дүн болно.</p> <p>4.3. Төлөвлөгдсөн блокын уулын цулын хэмжээг өрөмдсөн блокын хэмжилт, ӨТА-н паспортоор тооцож гаргана.</p> <p>4.4. Тэслэгдэхээс өмнөх болон тэслэгдсэн блокын ухаж ачсаны дараах маркшейдерийн хэмжилтийг харьцуулж уулын цулыг тооцно.</p> <p>4.5. Гэрээний 4.2-д заасан нийт ажлын талбайд хийгдэх ажил нь төлөвлөгөөний дагуу явагдах ба төлөвлөгөөт хэмжээ нь өөрчлөгдөж болох бөгөөд энэ тохиолдолд ажлын гүйцэтгэлийг хүлээн авсан актыг үндэслэн төлбөрийг тооцно.</p> <p>4.6. Тэсэлгээний ажлыг сар бүрийн 01-ний өдрөөр 2 талын маркшейдерийн хэмжилтээр дүгнэх ба уулын ажлын төлөвлөгөөний дагуу ажлын талбай ул, овор ихтэй чулуулгийн хэмжээ 1.2-т заасан шаардлагын дагуу хүлээн авч, тооцоо хийгдэнэ.</p> <p>4.7. Захиалагч тал нь гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажлын үр дүнг сар бүр актаар хүлээн авна.</p>																																
8	Ажлын хэмжээ	<p>Тэслэх уулын цулын хэмжээ:</p> <table border="1" data-bbox="625 1323 1315 1458"> <thead> <tr> <th>Үзүүлэлт</th> <th>Хэмжих нэгж</th> <th>Хэмжээ</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Нийт уулын цул</td> <td>м3</td> <td>4 811 935</td> </tr> </tbody> </table> <p>Баргилтын ил уурхайн уулын ажлын 2024 оны төлөвлөгөө:</p> <table border="1" data-bbox="625 1514 1353 1727"> <thead> <tr> <th>№</th> <th>Үзүүлэлтүүд</th> <th>Хэмжих нэгж</th> <th>2024 оны төлөвлөгөө</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Нийт уулын цул</td> <td>мян.м3</td> <td>4529.948</td> </tr> <tr> <td rowspan="2">2</td> <td rowspan="2">Хүдэр олборлолт</td> <td>мян.тн</td> <td>1800</td> </tr> <tr> <td>мян.м3</td> <td>466.322</td> </tr> <tr> <td>3</td> <td>Хөрс хуулалт</td> <td>м3</td> <td>4063.626</td> </tr> </tbody> </table> <p>2025 онд тэслэгдэх уулын цулын хэмжээ</p> <table border="1" data-bbox="625 1794 1353 1899"> <thead> <tr> <th>№</th> <th>Үзүүлэлтүүд</th> <th>Хэмжих нэгж</th> <th>2025 он</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Нийт уулын цул</td> <td>мян.м3</td> <td>281.987</td> </tr> </tbody> </table> <p>Ажлын хугацааг гэрээ байгуулж тогтооно.</p>	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээ	Нийт уулын цул	м3	4 811 935	№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2024 оны төлөвлөгөө	1	Нийт уулын цул	мян.м3	4529.948	2	Хүдэр олборлолт	мян.тн	1800	мян.м3	466.322	3	Хөрс хуулалт	м3	4063.626	№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2025 он	1	Нийт уулын цул	мян.м3	281.987
Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээ																																
Нийт уулын цул	м3	4 811 935																																
№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2024 оны төлөвлөгөө																															
1	Нийт уулын цул	мян.м3	4529.948																															
2	Хүдэр олборлолт	мян.тн	1800																															
		мян.м3	466.322																															
3	Хөрс хуулалт	м3	4063.626																															
№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2025 он																															
1	Нийт уулын цул	мян.м3	281.987																															

9	Бусад шаардлага	<p>5.1 Тэсэлгээний материал үйлдвэрлэх өөрийн үйлдвэртэй байх.</p> <p>5.2 Тэсэлгээний ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай аливаа тусгай зөвшөөрөл авах, сум орон нутагтай гэрээ байгуулах, орон нутгийн засаг захиргаанаас тушаал шийдвэр гаргуулах, зэрэг асуудлыг гүйцэтгэгч тал хариуцах бөгөөд ийнхүү хийгээгүйгээс гарсан аливаа хохирлыг Захиалагч тал хариуцахгүй.</p> <p>5.2 Давагдашгүй хүчин зүйл (УИХ, Засгийн газрын шийдвэр, Хууль тогтоомжийн өөрчлөлт, ажил хаялт, эдийн засгийн хямрал, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, гал түймэр, үер усны гамшиг болон бусад байгалийн гамшигт үзэгдэл, гадаад худалдааны хорио цээр болон экспорт, импортын хориг, терроризм, бусад багцын ХАБ-ын зөрчил)-ийн улмаас биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд захиалагч болон гүйцэтгэгч тал хариуцахгүй. Үүнтэй холбоотой захиалагч талаас ямарваа нэг төлбөрийн хариуцлага хүлээхгүй..</p>
---	------------------------	---